



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 заалт, Засгийн газрын 2021 оны 137 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Агаарын тээврийг хялбаршуулах журам”-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. “Агаарын тээврийг хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах зөвлөл”-ийн үйл ажиллагааны хүрээнд Засгийн газрын 2023 оны 174 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Зорчигчийн мэдээллийн системийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Агаарын тээвэрлэгчээс Зорчигчийн мэдээллийн төвтэй мэдээлэл дамжуулах, хүлээн авах үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Зорчигчийн мэдээллийн системийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх журам” болон “Агаарын тээвэрлэгчээс Зорчигчийн мэдээллийн төвтэй мэдээлэл дамжуулах, хүлээн авах үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хилийн хяналтын байгууллагууд, агаарын тээвэрлэгчдэд тус тус даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

080000007

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны  
01 дугаар сарын 10 ны өдрийн 103 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт



## ЗОРЧИГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙГ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг.Зорилго

1.Энэхүү журмыг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 174 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг хэрэгжүүлэхэд удирдлага болгоно.

### Хоёр.Ерөнхий зүйл

2.1.Зорчигчийн мэдээлэлд Зорчигчийн урьдчилсан мэдээлэл (“Advance Passenger Information” буюу “API”) болон Зорчигчийн нэрийн бүртгэл (“Passenger Name Record” буюу “PNR”)-ийн мэдээлэл (цаашид “API/PNR өгөгдөл” гэх) хамаарна.

2.2.Зорчигчийн мэдээллийн төв (цаашид “Төв” гэх) нь API/PNR өгөгдлийг олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгч (цаашид “агаарын тээвэрлэгч” гэх)-ээс цуглуулах, хадгалах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, ашиглах, харилцан солилцох, түүний аюулгүй байдлыг хангах, устгах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.3.API/PNR өгөгдлийг цуглуулж, боловсруулалт хийх нь терроризмын гэмт хэрэг, хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, хилийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг шалгахад чухал ач холбогдолтой бөгөөд хилийн хяналтын болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, эрсдэлийг бууруулан зорчигчийг улсын хилээр шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах боломжийг бүрдүүлнэ.

2.4.Төв нь зорчигчийг Монгол Улсын агаарын хилээр нэвтрэхээс өмнө үнэлж, терроризмын гэмт хэрэг, хүнд гэмт хэрэг, гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаанд оролцсон эсэхийг тогтоохын тулд эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлт, дэмжлэгтэйгээр API/PNR өгөгдлийг боловсруулна.

### Гурав.Оролцогч талууд, тэдгээрийн хүлээх үүрэг

3.1.Зорчигчийн мэдээллийн дэд бүтцийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд Төв, агаарын тээвэрлэгч, түүний нэрийн өмнөөс мэдээлэл дамжуулагч итгэмжлэгдсэн төлөөлөгч (цаашид “итгэмжлэгдсэн төлөөлөгч” гэх) болон “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам”-д заасан эрх бүхий байгууллагууд оролцоно.

3.2.Төв нь Монгол Улсын хилийн хяналт шалгалтыг сайжруулах, төрийн холбогдох байгууллагуудын мэдээлэл солилцох шуурхай байдлыг хангах,

терроризмтой тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлэх болон иргэдийн аюулгүй байдал, хүний эрхийг хангах зорилгоор байгуулагдсан олон улсын стандартад нийцсэн, зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нэгж бөгөөд агаарын тээвэрлэгчээс эрх бүхий байгууллагад Монгол Улсын олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн дагуу API/PNR өгөгдлийг гаргаж өгөхийг шаардана.

3.3. Агаарын тээвэрлэгч нь агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний үндсэн дээр агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага бөгөөд өөрийн мэдээллийн санд цуглуулсан API/PNR өгөгдөлд хамаарах хэсгийг буюу мэдээллийн зөрүүг Төвд тогтоосон журам, хугацааны дагуу үнэн зөв, бүрэн дамжуулна.

3.4. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь агаарын тээвэрлэгчийн нэрийн өмнөөс API/PNR өгөгдлийг үүсгэн дамжуулах гуравдагч этгээд бөгөөд агаарын тээврийн компанийн үйл ажиллагаа явуулж буй бүх нислэгийн чиглэлд шаардлагатай зорчигчийн мэдээллийг өгөх үүрэгтэй.

3.5. Эрх бүхий байгууллага нь "Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ын 2.22 дахь хэсэгт заасан Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар, Гаалийн ерөнхий газрыг хэлнэ.

3.6. Эрх бүхий байгууллага нь терроризмын гэмт хэрэг, хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, хилийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг шалгах зорилгоор API/PNR-ийн өгөгдөл болон түүний боловсруулалтын санд нэвтрэх эрхтэй бөгөөд өгөгдөлд хяналт тавьж, түүнийг хангалттай түвшинд хамгаалагдсан байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

### **Дөрөв. API/PNR өгөгдлийг дамжуулах, хүлээн авах**


4.1. Төв нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO), Дэлхийн гаалийн байгууллага (WCO), Олон улсын агаарын тээврийн холбоо (IATA)-ны хэм хэмжээг удирдлага болгон "Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ын 3.5, 3.6 дахь хэсэгт заасны дагуу зорчигчийн мэдээллийг цуглуулахад агаарын тээвэрлэгчээс API/PNR өгөгдлийг дараах форматын дагуу хүлээн авна.

4.1.1. API өгөгдлийг UN/EDIFACT PAXLST D02B болон UN/EDIFACT PAXLST D05B форматтай PAXLST мессежээр;

4.1.2. PNR өгөгдлийг PNRGOV EDIFACT (version 11.1 to 13.1) болон PNRGOV XML (version 13.1) форматтай мессежээр.

4.2. Агаарын тээвэрлэгч нь API/PNR-ийн өгөгдлийг B, IBM MQ, MQ, Webservices, SFTP хэлбэрээр дамжуулна.

4.3. Агаарын тээвэрлэгч нь API/PNR өгөгдлийг дамжуулахдаа "Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ын 3.1 дэх



хэсэгт заасан хугацааг баримтлах бөгөөд техникийн доголдол гарсан тохиолдолд өгөгдлийн аюулгүй байдлыг зохих түвшинд хангаж, бусад зохистой арга хэрэгслийг ашиглан цахим хэлбэрээр дамжуулна.

4.4.Төв нь тодорхой аюул заналтай холбогдуулан өгөгдөлд хандах тохиолдолд “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам”-д заасны дагуу хуваарь харгалзахгүйгээр PNR өгөгдлийг дамжуулахыг агаарын тээвэрлэгчээс нэн даруй шаардаж болно.

4.5.Агаарын тээвэрлэгч нь дараах тохиолдолд API/PNR өгөгдлийг Төвд дамжуулна:

4.5.1.Монгол Улс руу, эсхүл Монгол Улсаас эхтэй шууд нислэгийн үед зорчигчийг зорьсон газарт нь хүргэж байгаа агаарын тээвэрлэгч нь шаардлагатай зорчигчийн өгөгдлийг илгээх;

4.5.2.Түрээсийн агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэж байгаа агаарын тээвэрлэгч нь API/PNR өгөгдлийг илгээх;

4.5.3.Нэг болон түүнээс дээш агаарын тээвэрлэгчтэй аяллын дугаар хуваан эзэмшиж байгаа (code share) агаарын тээвэрлэгч нь тухайн нислэгийн бүх зорчигчийн мэдээллийг нисэн очих эцсийн цэг буюу тухайн улсад илгээх;

4.5.4.Нэг агаарын тээвэрлэгч үйлдэж байгаа дамжин өнгөрөх нислэгийн хувьд нэг ижил аяллын дугаартай байх ба аялал эхэлсэн цэгээс болон дамжин өнгөрөх цэгээс ирж буй зорчигчийн API/PNR өгөгдлийг эцсийн цэгт илгээх;

4.5.5.Монгол Улсаар дамжин өнгөрөх нислэгийн үед тухайн чиглэлээс ирсэн бөгөөд дамжих үедээ хилээр нэвтрэх хүсэлт гаргаагүй эцсийн цэг хүртэл зорчих зорчигчийн API/PNR өгөгдлийг хүлээн авч дамжуулах бөгөөд мэдээлэл дамжуулах хугацаа нь агаарын хөлөг хөөрсөн цагаас хамаарна.

4.5.6.Дамжин өнгөрөх нислэгийн үед дундын цэгээс аялал эхэлж байгаа зорчигчийн API/PNR өгөгдлийг дундын цэгээс эцсийн цэгт дамжуулах бөгөөд дамжуулах хугацаа нь дундын цэгээс агаарын хөлөг хөөрсөн цагаас хамаарна.

4.6.Төв нь агаарын тээвэрлэгчтэй холбогдоход дараах үе шатыг хэрэгжүүлнэ:

4.6.1.Системийн холболт хийх - Холболтын үе шат нь агаарын тээвэрлэгч, нисэх буудлын ашиглаж байгаа системүүд болон зорчигчийн тооноос хамаарна. Төв нь агаарын тээвэрлэгчийг итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй эсэхээс үл хамааран нэн түрүүнд агаарын тээвэрлэгчтэй холбогдоно.

4.6.2.Техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлох - Холболтын үе шатанд техникийн болон үйл ажиллагааны бүх үзүүлэлтийг тодорхойлох бөгөөд үүнд сүлжээний хаяг, ашигласан протокол, түлхэх хугацаа зэрэг үзүүлэлтийг хамруулна.

4.6.3.Туршилтын системээр дамжуулан жишээ мессеж солилцох - Агаарын тээвэрлэгчийн дамжуулж байгаа API/PNR өгөгдлийг боловсруулах боломжтой эсэхийг шалгахын тулд туршилтын системийг ашиглан жишээ мессежүүдийг солилцох бөгөөд солилцсон үзүүлэлтүүд нь зөв, өгөгдөлтэй ажиллах боломжтой эсэхийг баталгаажуулна.



4.6.4.Баталгаажуулах - Төвийн системд холбогдохын тулд агаарын тээвэрлэгч бүр баталгаажуулалтын үе шатыг давна. Энэ үе шатанд агаарын тээвэрлэгч болон Зорчигчийн мэдээллийн төвийн системийн хооронд бүрэн ажиллагаатай эсэхийг баталгаажуулна. Баталгаажуулалтын үе шат дараах байдлаар зохион байгуулагдана.

а)жишээ мессежийг зөв хүлээн авах, боловсруулах;

б)урьдчилан тодорхойлсон туршилтын тохиолдлуудыг зөв боловсруулах.

Баталгаажуулалтын үе шат амжилттай дууссаны дараа Төв нь агаарын тээвэрлэгчид мэдэгдэнэ.

4.6.5.Боловсруулалтын системд нэвтрэх - Баталгаажуулалтын үйл явц дууссаны дараа агаарын тээвэрлэгч нь Төвийн системд нэвтрэх боломжтой болох ба API/PNR өгөгдлийг Төвд илгээж, тэдгээрийг бүрэн боловсруулна.

4.6.6.Тасралтгүй ажиллагаа ба хяналт - Төв нь системд илгээсэн API/PNR өгөгдлийг байнга хянаана. Агаарын тээвэрлэгчээс дамжуулсан өгөгдөл нь техникийн шаардлагад нийцэхгүй бол агаарын тээвэрлэгч эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбогдож асуудлыг аль болох түргэн шуурхай шийдвэрлэнэ.

### **Тав.Хариуцлага**

5.1.Агаарын тээвэрлэгч нь API/PNR өгөгдлийг агаарын хөлөг хөөрөхөөс өмнө эрх бүхий байгууллагад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүргүүлээгүй, эсхүл мэдээллийг дутуу хүргүүлсэн болон мэдээллийн системд хууль бусаар нэвтэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны  
01 дугаар сарын 10-ны өдрийн 103 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



**АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧЭЭС ЗОРЧИГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН  
ТӨВТЭЙ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ, ХҮЛЭЭН АВАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго Зорчигчийн мэдээллийн төвд олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг дамжуулах, хүлээн авах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зорчигчийн мэдээллийн төв нь олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авч, харилцан мэдээлэл солилцоход Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн 2178 (2014), 2396 (2017), 2482 (2019) тогтоолууд, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын Хавсралт 9, Засгийн газрын 2021 оны Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 261 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны "Журам, бүтэц, орон тоо батлах тухай" 174 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам", "Зорчигчийн мэдээллийн системийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх журам" болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

1.3. Зорчигчийн мэдээллийн төв нь "Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ын 1.5 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэн холбогдох Монгол Улсын олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжийн дагуу зорчигчийн боловсруулагдсан мэдээллийг эрх бүхий байгууллага болон олон улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай харилцан солилцоно.

1.4. Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгч нь улсын хилээр нэвтрэх зорчигчийн мэдээллийг Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын Хавсралт 9, Doc 9944-т тусгагдсан стандарт, практик зөвлөмжийн хүрээнд цуглуулан, хүний хувийн мэдээллийн нууцлал, хүний эрхийн тухай болон бусад эрх зүйн актуудтай уялдуулан Зорчигчийн мэдээллийн төвд дамжуулна.

1.5. Энэхүү журам нь "Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам", "Зорчигчийн мэдээллийн системийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх журам"-ийг хэрэгжүүлэх баримт бичиг мөн.

1.6. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1.6.1. "Агаарын тээврийн үйлчилгээнд оролцогч байгууллагууд" гэж (цаашид "талууд" гэх), Зорчигчийн мэдээллийн төв (цаашид "Төв гэх"), олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгч (цаашид "агаарын тээвэрлэгч гэх"), агаарын

тээвэрлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч (цаашид "итгэмжлэгдсэн төлөөлөгч" гэх)-ийг;

1.6.2. "Зорчигчийн мэдээлэл" гэж (цаашид "API/PNR өгөгдөл гэх") "Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ын 1.3 дахь хэсэгт заасан мэдээллийг;

1.6.3. "API өгөгдөл" гэж олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийн нислэгийн талаарх ерөнхий мэдээлэл, зорчигч болон агаарын хөлгийн багийн гишүүний баримт бичигт байгаа өгөгдлөөс бүрдсэн цогц мэдээллийг;

1.6.4. "PNR өгөгдөл" гэж агаарын тээвэрлэгчээс эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс зорчигчийн захиалгын дагуу агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой арилжааны болон үйл ажиллагааны зорилгоор ашиглах дэлгэрэнгүй мэдээллийг;

1.6.5. "Зорчигчийн мэдээллийн нэг цонх" гэж (цаашид "нэг цонх" гэх) "Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ын 1.4 дэх хэсэгт заасны дагуу API/PNR өгөгдлийг нэг шугамаар дамжуулахыг.

### **Хоёр.Зорчигчийн мэдээллийн нэг цонхны бүтэц, зохион байгуулалт**

2.1.Нэг цонх нь талууд Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 9 дүгээр хавсралтад тусгагдсан зорчигчийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавигдах стандарт, шаардлагын дагуу API/PNR өгөгдлийг нэг цэгт байршуулах боломжийг бүрдүүлэх систем юм.

2.2.Агаарын тээвэрлэгч нь "Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ын 3.5, 3.6 дахь хэсэгт заасны дагуу API/PNR өгөгдлийг бүрдүүлж, тус журмын 5.3-5.7 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан нэг цонх руу дамжуулна.


2.3.Агаарын тээвэрлэгчээс нэг цонх руу дамжуулах өгөгдөл нь үнэн зөв, бүрэн гүйцэд байна.

2.4.Төв нь нэг цонхонд нэгтгэн дамжуулагдсан API/PNR өгөгдлийг хослуулан үр дүнтэй ашиглах зарчмыг баримтална.

### **Гурав.Мэдээллийн нууцлал, хамгаалалтын арга хэмжээ**

3.1.Агаарын тээвэрлэгч нь терроризмын гэмт хэрэг, хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, хилийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг шалгах зорилгын хүрээнд API/PNR өгөгдлийг цуглуулах, боловсруулах, дамжуулах талаар зорчигчдод урьдчилан мэдэгдэнэ. Мэдэгдэлд зорчигчийн хувийн өгөгдлийг хамгаалахтай холбоотой эрх зүйн хэм хэмжээний талаар дурдсан байна.

3.2.Агаарын тээвэрлэгч, нислэгийн тийз борлуулагч нь хуульд зааснаас бусад тохиолдолд зорчигчийн мэдээллийг цуглуулах, ашиглахдаа Хүний хувийн мэдээлэл



хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу мэдээллийн эзнээс зөвшөөрөл авна.

3.3.Төв нь агаарын тээвэрлэгчээс Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд хүлээн авсан хувь хүний эмзэг мэдээлэл агуулсан PNR өгөгдөлд боловсруулалт хийхгүйгээр устгана.

3.4.API/PNR өгөгдлийг цуглуулах, дамжуулах, хүлээн авах үйл ажиллагаанд оролцох агаарын тээвэрлэгч болон эрх бүхий байгууллагууд нь өөрийн ажилтнуудад зорчигчийн мэдээллийн нууцлалыг хамгаалахтай холбоотой эрх зүйн хэм хэмжээний талаар болон тэдний хүлээх үүрэг, хариуцлагын талаар хууль, эрх зүйн мэдлэг олгоно.

3.5.Зорчигчийн мэдээллийг албан ажлын бус зорилгоор ашиглахыг хориглоно.

3.6.Зорчигчийн мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх, задруулах, урвуулан ашигласан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### **Дөрөв.Агаарын тээвэрлэгчийн үүрэг, хариуцлага**

4.1.Агаарын тээвэрлэгч нь “Зорчигчийн мэдээллийн системийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх журам”-ийн 4 дүгээр бүлэгт заасны дагуу API/PNR өгөгдлийг цуглуулж, дамжуулна.

4.2.Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл дамжуулалтын гүйцэтгэл болон чанарын хяналтын эцсийн хариуцлагыг тухайн агаарын тээвэрлэгч өөрөө хүлээнэ.

4.3.Агаарын тээвэрлэгч нь Төвд нисэх багийн гишүүдийн зөвхөн API өгөгдлийг дамжуулах бөгөөд PNR өгөгдлийг дамжуулахгүй.

4.4.Агаарын тээвэрлэгч дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.4.1.API/PNR өгөгдлийг цуглуулах, дамжуулах асуудлыг хариуцах нэгж эсхүл албан тушаалтныг томилох;

4.4.2.Техникийн болон үйл ажиллагааны зохицуулалт хариуцах мэдээлэл технологийн баг, ажилтныг томилох;

4.4.3.Төвтэй харилцан ажиллах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;

4.4.4.Холбогдох эрх бүхий байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах;

4.4.5.API/PNR өгөгдлийг дамжуулах итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагааг шалгах, баталгаажуулах;

4.4.6.Холбогдох журам, дүрэм, заавар боловсруулан хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах;





4.4.7. Үзлэг шалгалт хийх, үйл ажиллагааны хугацаанд тогтмол туршилт хийж системийн ажиллагааг шалгаж баталгаажуулах.

### **Тав. Агаарын тээвэрлэгчийг Төвтэй холбох үйл ажиллагаа**

5.1. Төв нь агаарын тээвэрлэгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийг үйл ажиллагааны цар хүрээгээр нь эрэмбэлэн зорчигчийн мэдээллийн системд холбох дараалал, үе шатыг тогтоох ба тэдгээрийн хүлээх үүрэг, хариуцлага, хүн хүчний хуваарилалтын талаар харилцан мэдээлэл солилцож, холболтын ажиллагааны хэвийн нөхцөлийг хангана.

5.2. Төв нь анхан шатны мэдээлэл солилцох хамтын ажиллагааны хүрээнд агаарын тээвэрлэгчийг дараах мэдээллээр хангана:

5.2.1. "Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам";

5.2.2. "Зорчигчийн мэдээллийн системийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх журам";

5.2.3. Энэхүү журам болон холбогдох хууль, тогтоомж.

5.3. Агаарын тээвэрлэгч нь дээрх баримт бичгүүдийг гадаад, дотоодын харилцагч байгууллагууддаа дамжуулан санал солилцож болно.

5.4. Төв нь API/PNR өгөгдлийг боловсруулахад эхний ээлжид нэг агаарын тээвэрлэгчийг сонгон, мэдээллийн системд холбох ажлыг зохион байгуулж, туршилтын ажлыг эхлүүлэх ба туршилтын хугацаанд илэрсэн алдаа, дутагдлыг арилгах арга хэмжээг авна.

5.5. Төв нь холболтын ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд агаарын тээвэрлэгчээс дараах багц мэдээллийг агуулсан асуумжийг хүргүүлж, мэдээллийг авна. Үүнд:

5.5.1. Холбоо барих мэдээлэл;

5.5.2. API/PNR өгөгдлийг дамжуулж байсан туршлага;

5.5.3. Техникийн хүчин чадал;

5.5.4. Агаарын тээвэрлэгчийн харилцан ажилладаг байгууллагууд.

5.6. Төв нь асуумжийн хариултад дүн шинжилгээ хийж, агаарын тээвэрлэгчтэй холбох ажлыг үе шаттайгаар, эрэмбэ дараалалтай зохион байгуулах төлөвлөлтийг боловсруулна.

5.7. Холбох эрэмбэ дараалал, хугацаа нь дараах хүчин зүйлсээс хамаарна:

5.7.1. Агаарын тээвэрлэгчийн зорчигч тээвэрлэх ачаалал;

5.7.2. Агаарын тээвэрлэгчийн олон улсын нислэгийн чиглэлүүд, зөрчил үүсэж болох чиглэлүүд;



5.7.3.Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл;  
5.7.4.Агаарын тээвэрлэгч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн техник хангамж, дэд бүтэц болон нөөц.

5.8.Агаарын тээвэрлэгч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй үйл ажиллагааг зохицуулах гэрээ байгуулан, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байна.

5.9.Талууд нь мэдээллийн дэд бүтцэд доголдол, саатал гарахаас урьдчилан сэргийлж хариу арга хэмжээг шуурхай авч, үйл ажиллагааг 24/7 горимоор тасралтгүй явуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээллийг цахим шуудан болон утсан холбоогоор солилцоно.

### **Зургаа.Мэдээллийн системийг холбох техникийн үе шат**

6.1.Агаарын тээвэрлэгч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийг API/PNR өгөгдлийн мэдээллийн системд холбох зөвшөөрлийн үйл явц нь ерөнхий 2 үе шатаас бүрдэнэ:

6.1.1.Баталгаажуулалтын үе шат:

Энэ үе шатанд мэдээлэл дамжуулах горим, протокол, аюулгүй байдлын түвшин, мэдээллийг бүрэн, үнэн зөв хүлээн авах зэргийг үйл ажиллагааны өмнөх урьдчилсан туршилтын шатанд янз бүрийн хувилбараар шалгаж турших ажлыг хийнэ.

6.1.2.Үйл ажиллагааны үе шат:

Энэ үе шатанд зорчигчийн бодит мэдээллийг дамжуулах ажлыг хийнэ.

6.2.Мессежийн формат, сүлжээний хаяг, дамжуулах горим, протокол, дамжуулах хугацаа гэх мэт техникийн болон үйл ажиллагааны бүх шалгуур, шаардлага, үзүүлэлтийг дээр дурдсан 2 үе шатанд шалгаж, эцэслэн баталгаажуулна.

6.3.Урьдчилсан туршилтын болон үндсэн үйл ажиллагааны үе шатуудад тус тусдаа холболтууд хийх шаардлагатай бөгөөд холболт бүрд Х509 сертификат болон нууц нэвтрэх эрх үүсгэнэ.


6.4.НҮБ-ын "GoTravel" системийг хэрэгжүүлэхэд мэдээлэл дамжуулах горимын техникийн заавар шаардлагатай бөгөөд уг систем нь мэдээллийг дараах 3 төрлийн механизмаар цуглуулж, дамжуулна:

6.4.1.В2В автомат сервисээр;

6.4.2.Цахим хуудасны маягтаар (жижиг агаарын тээвэрлэгч, нисэх багт зориулсан цахим маягтын систем);

6.4.3.XML хэлбэрээр.

6.5.Төв, агаарын тээвэрлэгч нь техникийн саатал, доголдол гарах, бүртгэлд байхгүй агаарын хөлөг ослын буулт хийх зэрэг онцгой тохиолдолд авах арга



хэмжээний талаар хамтарсан төлөвлөлт боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллана.

6.6.Баталгаажуулалтын орчин: агаарын тээвэрлэгчийг төвтэй холбоход IPSEC (Internet Protocol Security), эсхүл SSL (Secure Sockets layer) чадамжтай сүлжээ шаардлагатай.

6.7.Агаарын тээвэрлэгч нь Төвтэй холбогдох холболтын баталгаажуулалтын болон үйл ажиллагаа эхлүүлэхээс өмнө X509 нийтийн болон хувийн түлхүүрийн гэрчилгээтэй, шаардлага хангасан сүлжээгээр баталгаажсан байна.

6.8.Төв нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үүднээс НҮБ-ын Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр, Мэдээлэл, харилцаа холбооны технологийн газартай хамтран өөрийн нийтийн болон хувийн түлхүүрийн гэрчилгээтэй болох арга хэмжээг авна.

6.9.Гэрчилгээжилт хийгдэж дуусмагц агаарын тээвэрлэгч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийг Төвтэй холбох туршилтын ажил хийгдэнэ.

6.10.Туршилтын мэдээлэл илгээх, солилцох: үйл ажиллагааны өмнөх баталгаажуулалт хийгдмэгц агаарын тээвэрлэгч эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь бодит, гэхдээ тусгайлан түүвэрлэсэн мэдээлэл дамжуулж, ямар нэгэн алдаа, саатал, зөрчил илэрч буй эсэхийг туршиж баталгаажуулна.

6.11.НҮБ-ын "GoTravel" системийн багцад агуулагддаг PAXLST, PNRGOV мессежүүдийг шууд болон дамжин өнгөрөх нислэгийн жишээн дээр туршина.

6.12.Дамжуулсан туршилтын API/PNR өгөгдөл нь эмзэг мэдээлэл гэж үздэг ба нэмэлт хамгаалалт шаардлагатай бөгөөд PNR өгөгдөл нь тусгай үйлчилгээний хүсэлт (SSR) зэрэг мэдээллийг агуулсан байх ёстой.


6.13.Дамжуулсан API/PNR өгөгдлийг мэргэжлийн болон техникийн хувьд шалгах бөгөөд эхний ээлжинд мессежийн агуулгыг шинжлэх бөгөөд дараагийн ээлжинд өгөгдлийг техникийн аргаар боловсруулах боломжтой эсэхийг шалгана.

6.14.Төв нь туршилт амжилттай явагдаж, зөвшөөрлийн үйл явц дууссан тухай агаарын тээвэрлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

6.15.Мэдэгдэл нь холбогдох журамд заасан төвийн хэрэгцээ шаардлагыг хангасан эсэх, API/PNR өгөгдлийн мессежийн формат, хувилбар, дамжуулах хугацаа, өгөгдлийн чанар, бүрэн бүтэн байдал, торгуулийн журам, холбоо барих хаяг зэргийг тусган агаарын тээвэрлэгч бүрт тусгайлан боловсруулагдсан байна. Энэхүү мэдэгдлийг агаарын тээвэрлэгч итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан API/PNR өгөгдлийг дамжуулж буйг хэдий ч хууль эрх зүйн нийцлийг баталгаажуулахын тулд тухайн агаарын тээвэрлэгч рүү эхэлж илгээнэ.

6.16.Мэдэгдэл нь холболтын процессыг дуусгаж, үйл ажиллагаанд ашиглаж эхлэхийг тодорхойлно.

6.17.Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь API/PNR өгөгдлийн мессежийн формат, хувилбар, дамжуулах хугацаа, харилцан ажиллагааны талаар зохицуулалтыг холбогдох дүрэм, журамд тусгах саналыг оруулж болно.



6.18. Үйл ажиллагааны орчин: Дээрх туршилт, баталгаажуулалтын ажлууд дуусмагц агаарын тээвэрлэгч холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд өөрийн тээвэрлэж буй зорчигчийн API/PNR өгөгдлийг төвийн систем рүү дамжуулж эхэлнэ.

### **Долоо.Тасралтгүй үйл ажиллагаа**

7.1. Агаарын тээвэрлэгчийг төвтэй амжилттай холбосны дараа 24/7 горимоор үйл ажиллагааг тасралтгүй явуулах ба олон улсын бүх нислэгийн зорчигчийн API/PNR өгөгдлийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, дамжуулах ажлыг төвлөрсөн байдлаар зохион байгуулах ажлыг Төв хариуцна.

7.2. Төв нь бүх мэдээллийн чанарыг хянаж, ямар нэгэн алдаа, доголдол гарвал тухайн агаарын тээвэрлэгч эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбогдож асуудлыг шуурхай шийдвэрлэнэ.

7.3. Талууд нягт хамтран ажиллаж, системийн байнгын хяналт, сайжруулалт хийн, бүх үйл ажиллагааг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шуурхай, жигд зохион байгуулна.

7.4. Төв нь API/PNR өгөгдлийг дамжуулахтай холбоотой үйл явцыг жигдрүүлэх, мэдээлэл дамжуулах механизмын үр ашгийг нэмэгдүүлэх ажиллагааг зохицуулж ажиллана.

7.5. Төв нь системд дамжуулж буй API/PNR өгөгдлийн чанар, аюулгүй байдал, цаг хугацааг байнга хянаж, засвар, үйлчилгээ, зохицуулалт, сайжруулалт хийх бөгөөд холбогдох талуудтай байнга санал солилцож, шаардлагатай бол хууль тогтоомжид заасны дагуу сануулах, анхааруулах, торгох болон хариуцлага тооцох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

7.6. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Төв нь агаарын тээвэрлэгчийг дараах шаардлагыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина.

7.6.1. API өгөгдлийг саадгүй дамжуулах;

7.6.2. API өгөгдлийг тодорхой загвар, форматаар тогтоосон цаг хугацаанд дамжуулах;

7.6.3. API өгөгдлийг бүрэн гүйцэд, зөв дамжуулах.

7.7. Дээрх шаардлагуудыг хангахгүй байх тохиолдолд Төв нь холбогдох эрх бүхий байгууллагад зохих хариуцлага тооцох талаар санал болгох ба хариуцлага тооцоход дараах шат дараатай арга хэмжээг авна:

7.7.1. Хариуцлага тооцож болзошгүй талаар анхааруулах;

7.7.2. Сануулах;

7.7.3. Хариуцлага тооцох.

7.8. Систем, техникийн алдаа, саатлаас бусад тохиолдолд, API/PNR өгөгдөл дамжуулахтай холбоотой үүргээ зохих ёсоор биелүүлээгүй агаарын тээвэрлэгчдэд



эрх бүхий байгууллагаас холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.

7.9.Төвийн агаарын тээвэрлэгчтэй харилцах ахлах ажилтан нь эрх бүхий байгууллагаас зорчигчийн бичиг баримтын мэдээллийг авч, агаарын тээвэрлэгчийн мэдээлэлтэй тулгаж, тухайн агаарын тээвэрлэгчийн алдаа, буруу байгаа эсэхийг тодорхойлно.

7.10.Агаарын тээвэрлэгч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл дамжуулах системд урьдчилан мэдэгдээгүй тасалдал гарсан тохиолдолд үүнийг илрүүлсэн даруйдаа Төвд мэдэгдэх бөгөөд ажлын өдөр тасалдсан тохиолдолд 24, амралтын өдөр тасалдсан тохиолдолд 72 цагийн дотор API/PNR өгөгдлийг шинээр бүрэн дамжуулна.

7.11.Агаарын тээвэрлэгч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөө солих шийдвэр гаргах тохиолдолд Төвд 6 сараас багагүй хугацааны өмнө, шинэ чиглэл нээхээр болсон тохиолдолд аль болох хангалттай хугацааны өмнөөс Төвд мэдэгдэнэ.

7.12.Төв нь системийн болон үйл ажиллагааны чиглэлээр өөрчлөлт хийх тохиолдолд агаарын тээвэрлэгчдэд хангалттай хугацааны өмнө мэдэгдэнэ.

7.13.Холбогдох олон улсын стандарт, дотоодын хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг энэхүү журамд тусган хэрэгжүүлнэ.

---oOo---

